ӦНЗа
Тэнцвэртэй сэтгэл зүй, Гэгээлэг ирээдүй

# ОНЗА-гийн Боловсролын зөвлөхийн ёс зүйн дүрэм

**1. Үйлчлүүлэгч 1-т**

Бид үйлчлүүлэгч бүрийн сонирхол, зорилгыг нэн тэргүүнд тавьж, боловсролын зөвлөгөөг хувь хүн бүрийн онцлогт тохируулан, хараат бус, урт хугацааны хөгжил дэвшил, сайн сайхан байдалд нь дэмжлэг болох байдлаар өгнө.

**2. Ил тод байдал**

Бид боломжит сургалтын хөтөлбөрүүд, төлбөрийн бүтэц, визний шаардлага болон амьдрах орчны нөхцөл байдлын талаар үнэн бодит, шинэлэг, тэнцвэртэй мэдээллийг өгнө. Бодит бус амлалтууд өгөхгүй.

**3. Нууцлал**

Бид үйлчлүүлэгч, тэдний ажил олгогчийн, ивээн тэтгэгчийн, гэр бүлийн хувийн, боловсролын, санхүүгийн нөхцөл байдлын мэдээллийг чандлан хадгалж, зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрлөөр холбогдох талуудад хуваалцана.

**4. Хүндлэл**

Бид үйлчлүүлэгчийг боловсрол, нийгмийн гарал үүсэл, ажил албан тушаал, үзэл бодол, итгэл үнэмшлээс үл хамааран тэгш, хүндэтгэлтэй хандана.

**5. Мэргэжлийн байдал**

Бид хамтран ажилладаг сургуулиудын дүрэм журмыг сахин мөрдөж, ашиг сонирхлын зөрчилгүй, мэргэжлийн түвшний үйлчилгээг үзүүлнэ.

**Зөвлөхийн нэр, гарын үсэг, огноо...................................**